



МОНГОЛ АЛТ ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 04 сарын 21-ны өдөр

№ 01

Дархан хот

Хувьцаа эзэмшигчдийн хурал 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 10:00 цагт Монгол-Алт ХК-ийн офисийн хурлын танхимд эхлэв.

Хурлын ирц: Хуралд хувьцаа эзэмшигч М.Цолмон, Л.Амарсанаа, Б.Батром, М.Оюун, Ж.Мягмаа, А.Болор-Эрдэнэ, Л.Базарсад нар оролцов. Хувьцаа эзэмшигч М.Оюун нь хувьцаа эзэмшигч Ж.Мөнхтөр, М.Жавхлан нарыг итгэмжлэлээр, хувьцаа эзэмшигч Б.Саруулыг Б.Цэлмэг итгэмжлэлээр төлөөлөх эрхтэйгээр хуралд оролцов.

Компанийн нийт энгийн 265852 ширхэг хувьцаанаас 235896 ширхэг энгийн хувьцааг эзэмшигчид буюу 88,7 хувийн ирцтэйгээр хурал эхлэв.

Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2023 оны 03 сарын 06-ны өдрийн хурлаар хувьцаа эзэмшигч Л.Амарсанааг Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаар томилсныг нийт хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчид 100 хувь санал нэгтгэйгээр зөвшөөрөв.

Хурлын дарга Л.Амарсанаа хурлын ирц болон хурлаар хэлэлцэх асуудлын дараалал, хурлын дотоод журмыг танилцуулав.

Л.Амарсанаа: -Хэлэлцэх асуудалтай холбоотой санал хэлэх хувьцаа эзэмшигч байна уу? Байхгүй байна.

За, хэлэлцэх асуудлыг дарааллыг батлах санал хураалтыг явуулъя.

Хэлэлцэх асуудлыг санал нэгтгэйгээр дэмжиж батлав.

Хуралдааны дотоод журмыг батлах санал хурааа. Дэгийг санал нэгтгэйгээр батлав.

ХЭЛЭЛЦСЭН нь: - За, эхний асуудлаа хэлэлцье. Компанийн 2022 оны санхүүгийн тайланг сонсож хэлэлцэнэ. Ерөнхий нягтлан бодогч Ж.Мягмаа танилцуулна.

Ж.Мягмаа: - Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралдаанд хүрэлцэн ирсэн нийт хувьцаа эзэмшигчдэд энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

Монгол-Алт ХК-ийн 2022 оны санхүүгийн тайланг танилцуулъя. Манай компанийн санхүү тайлант онд түрээсийн орлого, улсын төсвийн санхүүжилтээр гүйцэтгэж байгаа ажлын орлогоос бүрдсэн. Энэ онд өмнөх онуудаас эхлэн гүйцэтгэж ирсэн ажлын тайлан хаагдана. Хаагдсан тохиолдолд орлогыг хүлээн зөвшөөрч санхүүгийн тайландаа тусгах ёстой.

Санхүүгийн тайлангийн дэлгэрэнгүй задаргааг уншиж танилцуулав.

М.Цолмон:- Санал байна. Санхүүгийн тайлангийн дэлгэрэнгүй танилцуулгыг дараагийн ТУЗ-ийн хурлаар бүх гүйцэтгэх удирдлагуудыг бүгдийг нь байлцуулж, нэг бүрчлэн танилцуулга бэлдүүлж сонсож хэлэлцэх нь зөв болов уу гэж бодож байна.

Ж.Мягмаа: - Ногдол ашгийн тухайд бид сүүлийн 23 жилд 920 сая төгрөгийн ногдол ашиг хуваарилсан. Сүүлийн 2 жил ногдол ашиг хуваарилаагүй байгаа.

ХЭЛЭЛЦСЭН нь

Л.Амарсанаа: - Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүдийн дүгнэлтийг О.Лувсаншарав танилцуулна. Түүний дараагаар асуулт, хариултдаа орцгооё.

О.Лувсаншарав: - 2022 оны Санхүүгийн тайланг сонслоо. Хараат бус гишүүдийн дүгнэлтийг танилцуулъя.

Дүгнэлтийг уншиж танилцуулав.

Л.Амарсанаа: - Монгол-Алт ХК-ийн 2022 оны санхүүгийн тайланг, Хараат бус гишүүдийн дүгнэлтийг тус тус сонслоо. Ингээд хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчид асуух, санал гаргах бол сонсьё.

М.Оюун: - Санал байна. Санхүүгийн тайлан, дүгнэлтийг хувилж тараах нь зөв шүү. Харьцуулж дүгнэлт хийхэд дөхөм байдаг.

Мөн энэ дашрамд ТУЗ-ийн гишүүний хувиар геологийн судалгааны ажилд үнэтэй хувь нэмэр оруулж, зүтгэл гаргаж байгаа Батром геологидоо талархсанаа илэрхийлж, баяр хүргэхийг хүсэж байна.

Л.Амарсанаа: - За, саналаа нар зөв тойроод хэлээд явчихъя. Батром геологид санал хэлэх зүйл байна уу?

Б.Батром: - Компанийн үйл ажиллагааг цаашид сайжруулах үүднээс өөрийн гадарлах геологийн судалгааны ажлын талаар товчхон мэдээлэл өгье.

Геологийн судалгааны ажил 2000 оноос үндсэндээ зогссон. Дараа нь уурхайтайгаа үлдээд байж байгаа тэр нь зогсоод 2020 оноос эргээд судалгааны ажлаа сэргээе гээд боловсон хүчнүүдээ бэлдээд, сургаад явъя гэсэн үүднээс 3 жилийн хугацаанд 3 төсөл хэрэгжүүлээд 2 нь дуусаж байна. Нэг нь 2 жил үргэлжлэх юм байна.

Тэгэхээр геологийн судалгааны ажил цаашдаа яаж явах нь ний нуугүй хэлэхэд бүрхэг. Нэгдүгээрт, яамны зүгээс 50 мянганы судалгааны ажлыг огт дэмжихгүй байдаг юм. Нөхцөл байдал хэцүү байгаа.

Тийм учраас залуучууд та бүхэн цаашид хөгжлийн чиг хандлагаа харж барилгын ч юм уу эрсдэл багатай, үр ашигт хөрөнгө оруулалт хийх нь зөв шүү.

Геологи, уул уурхай талын бизнес асар их санхүүжилт, хөрөнгө оруулалт шаарддаг эрсдэл зүйл болчихлоо. Ийм л зүйл хэлэх байна.

Л.Амарсанаа: - Төрийн дэмжлэгтээ л асуудал байна. Тийм үү?

Б.Батром: - Тийм. Ерөөсөө л төрийн дэмжлэгтээ байна. Энэ жил жишээ нь 50 мянганы зураглалын ажил нэг ч зарлаагүй. Энэ нь боловсон хүчний тогтвор суурьшилтай ажиллахад асар их нөлөөлж байна.

Л.Амарсанаа: - За, өөр саналтай хүн байна уу?

Л.Базарсад: - Ерөнхийдөө 3 жилийн өмнөөс Цолмон захирал маш сайхан санаа гаргаж геологийнхоо ажлыг сэргээе гээд дахин эхлүүлсэн нь сайн хэрэг юм. Гэхдээ геологийн ажил Батромын хэлдгээр дээр доороосоо хааж боогоод байхаар хэцүү юм. Энэ цаг хугацааны л асуудал байх л даа. Түүнээс биш тодорхой цаг хугацааны дараа үргэлжилж явах л байх л даа. Тэгэхээр энэ ажлаа бүр орхихгүйгээр явах ёстой.

М.Цолмон: - Хувьцаа эзэмшигчдийн тавьж байгаа асуулт, саналтай холбогдуулаад гүйцэтгэх захирлаар ажиллаад 3 жил болж байгаагийн хувьд тайлбар хийх нь зүйтэй байх.

Сургууль ямар ч байсан сүүлийн 2 жил ашигтай ажиллаж байгаа. Хүүхдийн тоо бол цөөрч байгаа. Сургалтын төлбөр нэмэхээр тоо цөөрч байгаа. Гэсэн ч манайх үнэтэй сургууль болчхоогүй байгаа. Энэ хичээлийн жилд дахиад нэмнэ. Сургалтынхаа чанар дээр сүүлийн үед анхаарч байгаа. Сургуулийнхаа алсын хараа, зорилтыг өөрчилье гэж бодож байгаа. Өмнө өв тэгш монгол хүнийг хүмүүжүүлнэ гэж зорьж байсан. Аль болох олон талт авъяасыг нь хөгжүүлэх концепцийг баримталж байсан тул аль талаар гүнзгийрч олимпиад, уралдаан тэмцээнд оролцдоггүй явж ирсэн.

Одоо эцэг эхчүүд буюу үндсэн хэрэглэгчдийн шаардлага хэрэгцээнд тулгуурлаж математик, англи хэлдээ гүнзгийрч суралцах боломжийг бүрдүүлэх ёстой.

Сайн багш авч ажиллуулсан. Үр дүн шууд гарсан. Дахиад сайн багш нарыг ажиллуулахаар төлөвлөж байна. Гадаад багшийн тоог нэмэгдүүлнэ.

Момо-Агро компани энэ жил сайн ажилласан. Өмнө ашиггүй ажиллаж байсан. Одоо ашигтай ажиллана гэж найдаж байгаа.

Компанийн салбар үйл ажиллагаануудын үр дүнгийн талаар танилцуулав.

ТУЗ-ийн үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай байгаа. Ковидын он жилүүдэд үйл ажиллагааны хэмнэл алдагдсан тал байгаа. Иймээс компанийн засаглалыг сайжруулж зарим өөрчлөлтүүдийг хийхээр төлөвлөж байна.

Л.Амарсанаа: - Миний хувьд бол та бүгдээсээ хүлцэл өчих зүйл байна. 2014 онд дипломат албанд томилогдоод 4 жил, ковидын он жилүүд гээд та бүхнийхээ ажил сайн тус болж чадсангүй.

Бид 2 хүнд үеийг давлаа. Уул уурхайн ажил дуусаад эрхэлж байсан ажил эрс тэрс өөрчлөгдөөд ажилгүй шахам болжээ. Ковидын хүнд үеийг давлаа.

Тэгэхээр бид хуучныхаа ажлын арга барилаар яваад байж цаашид болмооргүй юм шиг байна. Тэгэхээр бид нилээн дорвитой өөрчлөлт оруулж, ажлынхаа чиглэлийг их зөв олж авч зүтгэхгүй бол болмооргүй юм шиг байна.

Цолмон баг бүрэлдүүлэх төлөвтэй байна. Өөрөөр хэлбэл өмнөх уламжлал өөрчлөгдөж Цолмонг захирлаар ажиллуулж зүтгүүлэх гэж байна гэж би төсөөлж байна.

За, 50 мянганы зураглалын хувьд бол найдах үндэсгүй юм шиг байгаа юм. Төрийн бодлого уламжлагдаж явахгүй байна.

Үйл ажиллагааны чиглэл бүрээ ашигтай ажиллуулах шаардлагатай. Зарим асуудлуудыг жичдээ ярих юм байна.

За, ингээд санал шүүмжлэлийг тасалъя. Тогтоолын төслүүдээ батлах ёстой.

Нэгдүгээрт, 2022 оны Санхүүгийн тайлан, Хараат бус гишүүдийн дүгнэлтийг батлах тогтоолын төсөл дээр саналтай хүн байна уу? Байхгүй бол баталъя гэсэн гишүүд гараа өргөө.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: - 2022 оны Санхүүгийн тайлан, Хараат бус гишүүдийн дүгнэлтийг батлах тогтоолыг хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар батлав.

Хоёрдугаарт, Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүн Б.Саруул, Б.Батжаргал нар чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасантай холбогдуулан гишүүнээр Лувсандагвын Амарсанаа,

Батмөнхийн Цэлмэг нарыг сонгох тухай тогтоолын төсөл дээр саналтай хүн байна уу? Байхгүй бол баталъя гэсэн гишүүд гараа өргөө.


ШИЙДВЭРЛЭСЭН нь: - Төлөөлөн Удирдах зөвлөлийн зарим гишүүдийг сонгох тухай тогтоолыг хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар батлав.

Гуравдугаарт, Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2023 оны зардлын төсөв, дарга, гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг өмнөх оны жишгээр батлах тогтоолын төсөл дээр саналтай хүн байна уу? Байхгүй бол баталъя гэсэн гишүүд гараа өргөө.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: - Төлөөлөн Удирдах зөвлөлийн зарим гишүүдийг сонгох тухай тогтоолыг хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар батлав.

За, Монгол-Алт ХК-ийн хувьцаат компанийн 2023 оны ээлжит хурал амжилттай болж өндөрлөлөө. Хуралдаа хүрэлцэн ирж оролцсон нийт хувьцаа эзэмшигчдэдээ баярлалаа гэснээр хурал 11:04 минутад дуусав.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:



ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
С.Бат-Эрдэнэ